



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 112

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Орон Нутгийн Өмчийн Газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20,990,200 (хорин сая есөн зуун ерэн мянга хоёр зуу) төгрөгийн балансын үнэтэй, 4,081,427.63 (дөрвөн сая наян нэгэн мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 00-44 ДУЭ улсын дугаартай LEXUS 470 маркийн автомашины худалдах доод үнийг 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр.Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах.

Гурав.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн 4/2 тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газрын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэр-лэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			сери дугаар	дугаар			арлын дугаар	могорын эзлэхүүн				
1	Суудлын	Lexus 470	ДУЭ	00-44	2000	2011.04.15	JTJHT00W613506556	4464	168660	20,990,200	16,908,772.37	4,081,427.63
ДҮН												
<p>4,081,427.63 /дөрвөн сая наян нэгэн мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг жаран гурван мөнгө/</p>												